



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/382

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 39 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр байгуулсан "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн орчны хүртээмжийг сайжруулах гуравдугаар бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг нэгдүгээр, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг хоёрдугаар, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих стратегийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг гуравдугаар, ажлын хэсгүүдийн ажиллах удирдамжийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2 Төслийн хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсэг (С.Тунгалагтамир, Ц.Амартөгс, С.Рэгзэн)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаярт даалгасугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны
12 дугаар сарын 27 ны өдрийн 1 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН ОРЧНЫ
ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ДЭД АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтсийн дарга

Гишүүд: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга

Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Зам тээврийн хөгжлийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын Стандарт, нормативын хэлтсийн дарга

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн захирал

Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвийн дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Харилцаа холбоо, шуудангийн бодлого зохицуулалтын газрын дарга

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тусгай хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч

Стандарт, хэмжил зүйн газрын Стандартчилал, төхирлын үнэлгээний газрын дарга

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн дэд дарга

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах төслийн Хөдөлмөр эрхлэлт, хүртээмж, ойлголт хандлагын асуудал хариуцсан ажилтан

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)-ын
Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн
оролцоог дэмжих төслийн ахлах зөвлөх

Монголын тэргэнцэртэй иргэдийн холбооны тэргүүн
/зөвшилцсөнөөр/

Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөө үндэсний
зөвлөлийн тэргүүн /зөвшилцсөнөөр/

Сонсголын бэрхшээлтэй иргэдийн соёлын төвийн тэргүүн
/зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн
дарга:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн
газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтсийн
мэргэжилтэн

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

382

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Гишүүд: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтсийн дарга

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн мэргэжилтэн

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Бодлогын хэрэгжилтийн газрын дарга

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газрын дарга

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн захирал

Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн Мэргэжлийн ур чадвар олгох сургуулийн хичээлийн эрхлэгч

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах төслийн Хөдөлмөр эрхлэлт, хүртээмж, ойлголт хандлагын асуудал хариуцсан ажилтан

Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны төлөөлөл /зөвшилцсөнөөр/

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын төлөөлөл /зөвшилцсөнөөр/

Хөдөлмөрийн биржүүдийн нэгдсэн холбооны төлөөлөл /зөвшилцсөнөөр/

Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны ерөнхийлөгч /зөвшилцсөнөөр/

Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбооны
тэргүүн /зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн
дарга:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн
газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтсийн
мэргэжилтэн

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/
дугаар тушаалын гуравдугаар хавсралт /382

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭДЛЭХҮҮН**

- Дарга: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга
- Гишүүд: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтсийн дарга
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого төлөвлөлтийн газрын Нийгмийн хамгааллын хэлтсийн дарга
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн захирал
- Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвийн дарга
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн дарга
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хэвлэлийн төлөөлөгч
- Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дарга
- Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын мэргэжилтэн
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дэд дарга
- Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга

Үндэсний статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга /зөвшилцсөнөөр/

Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл

Түгээмэл хөгжил төв төрийн бус байгууллагын тэргүүн /зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А
дугаар тушаалын дөрөвдүгээр хэсрэлт /382

АЖЛЫН ХЭСГИЙН АЖЛЫН УДИРДАМЖ

1. ҮНДЭСЛЭЛ

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр Монгол Улсын Засгийн газар "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийг хэрэгжүүлж байна. Тус төсөл нь (i) хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх чадавхийг бэхжүүлж, тогтолцоог бүрдүүлэх (ii) ХБИ-дэд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах (iii) орчны хүртээмжийг сайжруулах (iv) ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих (v) ХБИ-ийг дэмжих стратегийг боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь тус төслийг хэрэгжүүлэх гол яам бөгөөд Эрүүл мэндийн яам төслийн зарим үр дүнг хариуцна.

2. ЗОРИЛГО

Ажлын хэсгийн зорилго нь "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хүрээнд ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орчны хүртээмжийг сайжруулах болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих стратегийг хэрэгжүүлэх бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэгч гадаад, дотоодын зөвлөх компани болон хувь зөвлөхүүдийн гүйцэтгэсэн ажлын явцын тайлан болон хүлээлгэн өгсөн баримт бичигтэй танилцах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажлын гүйцэтгэлийг үнэлэн бүтээгдэхүүн хүлээж авахад санал дүгнэлт гаргах, төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

3. АЖЛЫН ХЭСГИЙН ЧИГ ҮҮРЭГ

3.1. Хариуцсан асуудлын хүрээнд сонгогдсон зөвлөх компани, зөвлөхүүдийн ажлын явцын тайлантай улирал тутам танилцах, гэрээний үүргийн гүйцэтгэлийг хянах;

3.2. Үйл ажиллагаатай холбоотой тулгамдсан асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.3. Зөвлөх компани, зөвлөхүүдийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж, холбогдох баримт бичиг, мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

3.4. Шаардлагатай бол бусад байгууллагаас нэмэлт мэдээлэл авах уулзалтыг хамтран зохион байгуулах;

3.5. Зөвлөхүүдийн гүйцэтгэсэн ажлын чанар, үр дүнг хянан үнэлж, бүтээгдэхүүн хүлээх авах талаар санал дүгнэлт өгөх;

3.6 Төслийн удирдах хороонд ажлын явц, үр дүнгийн талаар танилцуулах, шаардлагатай бол холбогдох шийдвэрийг гаргуулах талаар санал гаргах.

4. АЖЛЫН ХЭСГИЙН ХАРИУЦАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Ажлын хэсэг нь дараахь хүрээний ажлын явцын болон хэрэгжилтийн талаарх тайлан болон хүлээлгэн өгсөн баримт бичигтэй танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг үнэлж, санал дүгнэлт гаргах боловч уг ажлаар хязгаарлагдахгүй болно.

4.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн орчны хүртээмжийг сайжруулах хүрээнд:

4.1.1. Барилга байгууламж, тээврийн хэрэгслийн болон мэдээллийн хүртээмжийн норм, стандарт, дүрэм журам, хуулиудын үнэлгээний тайлантай танилцаж, санал дүгнэлт өгөх, зөвлөхүүдийн боловсруулсан цаашид сайжруулах арга хэмжээний зөвлөмжийг хэлэлцэж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, холбогдох шийдвэр гаргуулах талаар санал гаргах;

4.1.2 Тусгай технологи, тусгай хэрэгсэл, нөхөн олгодог протез үйлдвэрлэл болон худалдан авалтын доод стандарт, журам боловсруулан батлуулах, чадавхи бэжжүүлэх сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

4.1.3. ХБХХЕГ-ын харъяа протез, ортопедийн үйлдвэр, МСҮТ-ийн тоног төхөөрөмж, тусгай хэрэгслийг сайжруулах зөвлөмжийг хэлэлцэж, санал өгөх, арга зүйгээр хангах;

4.1.4. Орчны хүртээмжид аудит хийх арга зүйг шинэчлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, аудит хийхэд дэмжлэг үзүүлэх;

4.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд:

4.2.1. ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, үйлчилгээ болон хөтөлбөрүүдийн үнэлгээтэй танилцан санал дүгнэлт гаргах, ХБИ-ийн оролцоог хангах ажлыг уялдуулан зохицуулах бодлогын зөвлөмжид санал өгөх;

4.2.2. ХБИ-ийн кейс менежментийг хөгжүүлэх, ажил олгогчидтой хамтын ажиллагааг сайжруулах талаар боловсруулсан санал зөвлөмжтэй танилцаж, үнэлж дүгнэх, хэрэгжилтийг зохион байгуулахад туслан дэмжих;

4.2.3. ХБИ-дэд хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлдэг ажилтнууд, ХБИБ-дад сургалт зохион байгуулах сургалтын хөтөлбөр, гарын авлага материалтай танилцан, зөвлөмж чиглэлээр хангах;

4.2.4. ХБИ-дэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн квотын системийн үнэлгээний тайланг хянан, шинэчлэх зөвлөмж, квотын системийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх, санал өгөх;

4.2.5. Хөдөлмөр эрхлэлтийн квотын тогтолцооны талаар холбогдох байгууллагууд болон ажил олгогчдын ойлголт дээшлүүлэх мэдээллийн компани ажлын зөвлөмжийг хэлэлцэж эцэслэх, хэрэгжилтэд хяналт тавих;

4.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих стратегийг хэрэгжүүлэх хүрээнд:

4.3.1. ХБИ-ийн талаарх олон нийтийн хандлага, ойлголтыг дээшлүүлэх арга хэмжээний саналыг хэлэлцэж, батлуулан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.3.2. Нийгмийн халамжийн бодлогын шинэчлэл, стратегийн саналыг боловсруулахад туслах, санал зөвлөмж өгөх;

4.3.3. ХБИ-ийг дэмжих үндэсний хөтөлбөрийн үнэлгээтэй танилцан зөвлөмж өгөх, дараагийн үе шатны үндэсний хөтөлбөрийн төсөлд санал өгөх, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

4.3.4. ХБИ-ийн амьжиргааны болон ядуурлын түвшин, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдалтыг тооцох шинэ эсвэл сайжруулсан судалгааны асуулга, мэдээлэлд дүн шинжилгээ хийх аргачлалтай танилцан санал дүгнэлт гаргах, чадавхижуулах сургалтын удирдамж боловсруулан хэрэгжүүлэхэд туслан дэмжих;

4.3.5. Инчеоны үзүүлэлтүүд дээрх тайлан, Инчеоны Стратегийг ХБИ-ийн Эрхийн тухай хуультай нийцүүлэх талаар зөвлөмж, сургалтын хөтөлбөр, гарын авлага, материалтай танилцан санал өгөх, сайжруулах чиглэлээр зөвлөмж өгөх, чадавхи бэхжүүлэх сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

4.3.6. Үйл хөдлөлийн олон улсын ангиллыг эрэлт, хэрэгцээ, боломжит нөөцөд нийцүүлэн Монгол Улсад нэвтрүүлэхэд шаардлагатай бодлогын үнэлгээнд санал

өгөх, үйл хөдлөлийн олон улсын ангиллын хялбаршуулсан хувилбарыг хэрэгжүүлэх, чадавхи бэхжүүлэх сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.

5. ГАРАХ ҮР ДҮН

5.1. Улирал тутам зөвлөх компани болон зөвлөхүүдийн ажлын явцтай танилцан, ажлын гүйцэтгэлийг хянасан байна.

5.2. Зөвлөх компани, зөвлөхүүдийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн, мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангаж ажилласан байна.

5.3. Зөвлөх компани, зөвлөхүүдийн гүйцэтгэсэн ажлын биелэлтийг үнэлж, бүтээгдэхүүн хүлээн авахад санал дүгнэлт гарган төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажилласан байна.

-----oOo-----

